

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Байршил: Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Эхлэх хугацаа: 2025/01/17

Дуусах хугацаа: 2025/02/17

Ажил эхлэх хугацаа: 2025/02

Цалин: Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:

- Байгууллагын дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах, ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллах;
- Байгууллагын үйл ажиллагааны тайлан төлөвлөгөөг нэгтгэн, дотоод хяналт, дүн шинжилгээ хийн үр дүнг тайлагнах;
- Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр хийгдэх аудитын үйл ажиллагааны зөвлөмжийн дагуу авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажиллах.

Тавигдах шаардлага:

- Магистр болон түүнээс дээш зэргийн боловсрол эзэмшсэн байх;
- Хуулийн болон дотоод хяналт шалгалтын чиглэлээр ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно;
- Мэргэжлээрээ хоёроос доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- Англи хэлний B2 түвшний мэдлэгтэй байх;
- Мэдээлэл боловсруулах, судалгаа хийж дүгнэлт гаргах, баримт бичиг боловсруулж тайлан гаргах чадвартай байх.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орох өргөдөл;
- Товч намтар – CV;
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон батламжийн хуулбар;
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа – 2 хувь.

Холбоо барих:

Та баримт бичгээ англи эсхүл монгол хэл дээр бэлтгэн 1 PDF файл болгон эмхэтгэж recruitment@gmit.edu.mn хаягаар бидэнд ирүүлнэ үү.

Цахим хуудас: www.gmit.edu.mn

Жич: Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярилцлагад урих болно.